



**“ТҮЛШ ХЭРЭГЛЭГЧДЭД ҮЙЛЧЛЭХ ТӨВ” ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 4/08

Улаанбаатар хот

┌ Стратегийн хэрэгжилтийг хянах, үнэлэх ┐
журмыг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв ОНӨААТҮГ-ын “Дүрэм”-ийн 5 дугаар зүйлийн 5.7.3 дахь заалт, “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.2.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв” ОНӨААТҮГ-ын 2025–2030 оны Стратегийн хэрэгжилтийг хянах, үнэлэх журмыг хавсралтаар баталсугай.

2. Бодлогын баримт бичгийг 2025 оны 05 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн нийт ажилтнуудад танилцуулж, мөрдлөг болгон ажиллахыг алба нэгжийн удирдлагуудад үүрэг болгосугай.

3. Бодлогын баримт бичиг батлагдсантай холбогдуулан шаардагдах хөрөнгийг тооцож, жил бүрийн төсөв, төлөвлөгөөнд тусган зориулалтын дагуу зарцуулахыг Санхүүгийн алба (Б.Батдолгиод)-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга Ц.Болормаад үүрэг болгосугай.


ДАРГА

Б.БАТТУЛГА





“ТҮЛШ ХЭРЭГЛЭГЧДЭД ҮЙЛЧЛЭХ ТӨВ” ОНӨААТҮГ-ЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ /2025-2030 ОН/



Энэхүү баримт бичиг нь “**ТҮЛШ ХЭРЭГЛЭГЧДЭД ҮЙЛЧЛЭХ ТӨВ**” ОНӨААТҮГ-ын чадавхыг бэхжүүлэх, нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах, хатуу болон хийн түлш хэрэглэгч айл өрхийг эрсдэлээс хамгаалах бодлого, үйл явцыг боловсронгуй болгож, үр дүнг нэмэгдүүлэх зорилго бүхий үйл ажиллагааны чиглэл, хүрэх үр дүн, шаардагдах нөөц зэргийг тусгасан дунд хугацааны хөгжлийн баримт бичиг юм.

АЛСЫН ХАРАА

“**ТҮЛШ ХЭРЭГЛЭГЧДЭД ҮЙЛЧЛЭХ ТӨВ**” ОНӨААТҮГ-нь нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах, нийтийн аюулгүй, эрүүл орчныг бүрдүүлэх, эрсдэлээс хамгаалах нэгдсэн бодлого, төлөвлөлтийг хэрэгжүүлэх, хяналт тавих мэргэшсэн хүний нөөц бүхий мэргэжлийн байгууллага болон төлөвшиж хөгжинө.

ЭРХЭМ ЗОРИЛГО

“**ТҮЛШ ХЭРЭГЛЭГЧДЭД ҮЙЛЧЛЭХ ТӨВ**” ОНӨААТҮГ нь Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах, угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх зорилгоор хатуу болон хийн түлш хэрэглэгч айл өрхүүдийн хэрэглээнд хяналт тавих, пийшин, яндан, зуухны битүүмжийг шалгах, засвар үйлчилгээ үзүүлэх, зөв галлагааны горим болон угаарын хийнээс сэргийлэх санамж, зөвлөмжийг түгээх, судалгаа мэдээлэл нэгтгэх, сургалт зохион байгуулах, угаарын хий мэдрэх төхөөрөмжийн ашиглалтад хяналт тавих, хяналтын системээр тасралтгүй хянах замаар эрсдэлээс урьдчилан сэргийлж, нийтийн аюулгүй, эрүүл орчныг бүрдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг тууштай хэрэгжүүлнэ.

ЗАРЧИМ, ҮНЭТ ЗҮЙЛ

- Хариуцлагатай байх:
- Ил тод, шударга байх:
- Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах:
- Хүн төвтэй байх :
- Мэдээлэл дээр суурилсан байх:
- Урт хугацааны тогтвортой байх:
- Хяналт, үнэлгээг эрхэмлэх:
- Инноваци, дэвшилтэт технологид суурилах:
- Байгальд ээлтэй хандлагыг баримтлах:



(SWOT ШИНЖИЛГЭЭ)

Давуу тал (S)	Сул тал (W)
Төрийн бодлогын дэмжлэгтэй	Санхүүгийн хязгаарлалт
Нийслэлд хэрэгцээ өндөр	Хүний нөөцийн тогтворгүй байдал
Туршлагатай хамт олон	Техник тоног төхөөрөмжийн хомсдол
Сургалт, хэвлэл мэдээллээр байнга мэдээлэх	Иргэдийн идэвх сул байх
Боломж (O)	Аюул (T)
Олон улсын байгууллагын дэмжлэг	Агаарын бохирдлын улирлын огцом нэмэгдэлт
Технологийн шинэчлэл	Иргэдийн мэдээлэл, хандлагын дутагдал
Хангамжийн урьдчилсан тооцоо гаргах	Төхөөрөмжийн хомсдол
Хяналт, урамшуулал, шийтгэл бүхий журам хэрэгжүүлэх	Мэдрэгч ашиглахгүй, осол гарах
	Ажилтны хариуцлага сулрах
	Систем тасалдах

Орчин үеийн технологи, мэдлэг, хүний нөөцөд тулгуурлан угаарын хийтэй холбоотой ослоос урьдчилан сэргийлэх, иргэдэд зөв мэдээлэл, хамгаалалт хүргэх, ажилтнуудын хариуцлагыг нэмэгдүүлж, аюулгүй орчныг бүрдүүлэх, мөн угаарын хийн хордлогоос бүрэн урьдчилан сэргийлж чаддаг, иргэдийн аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавьдаг, салбарын манлайлагч байгууллага болохын төлөөх дараах стратегийн зорилтуудыг дэвшүүлэв.

- I. **САЛБАРЫН МЭРГЭШЛИЙН ТҮВШНИЙ ТОГТОЛЦООГ БИЙ БОЛГОХ**
- II. **МЭДЭЭЛЛИЙН ДЭД БҮТЭЦ, ТЕХНИК ХАНГАМЖИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ**
- III. **САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН НЭГДСЭН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ**
- IV. **ХЭРЭГЛЭГЧИЙН БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ**
- V. **ХАМТЫН АЖИЛЛАГААГ ХӨГЖҮҮЛЭХ**
- VI. **ДУНД ХУГАЦААНЫ ЗОРИЛТЫН ДҮНГ ҮНЭЛЭХ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ СИСТЕМИЙГ БИЙ БОЛГОХ**




ЗОРИЛТ	ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛЛАГАА	ҮЙЛ	ХУГАЦАА	ХҮРЭХ ҮР ДҮН	ХАРИУЦАХ НЭГЖ
ЗОРИЛТ 1. САЛБАРЫН МЭРГЭШЛИЙН ТҮВШНИЙ ТОГТОЛЦООГ БИЙ БОЛГОХ	Үйлдвэрийн газрын үйл ажиллагааг тогтворжуулж, бэхжүүлэх -Үйлдвэрийн газрын одоогийн процесс, бүтцийн дүн шинжилгээ хийх -Салбарын ажил,мэргэжлийн стандарт, чадамжийн хүрээг тодорхойлох, боловсруулах -Мэргэшлийн зэрэг дэв, цалингийн сүлжээг бий болгох -Салбарын мэргэшлийн түвшний нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх -Салбарын үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт хийлгэж, дүгнэлт гаргуулах		2025-2030 он	Үйл ажиллагаанд ахиц дэвшил гарч тогтмол үр дүнтэй ажлуудаар бэхжүүлнэ. Ажил үүргийн хуваарь, үр дүн тодорхой болно. Хүний нөөцийн чадавх сайжирна -Ажилтны мэдлэг, ур чадварыг тодорхой түвшинд тогтоож, түүнд тохирсон сургалт, мэргэшүүлэлт явуулах боломж бүрдэнэ. -Ажилтан бүр үүрэг, хариуцлагаа ойлгож, үр дүнтэй ажиллах нөхцөл бүрдэнэ. Үйлчилгээний чанар, хүртээмж дээшилнэ -Нэгдсэн стандарт мөрдөх замаар ажил үйлчилгээний чанар жигд, найдвартай болно. -Иргэдэд хүргэх үйлчилгээ илүү шуурхай, чанартай, аюулгүй болж сайжирна. Ажлын байрны тодорхой байдал нэмэгдэнэ	Захиргаа, удирдлагын хэлтэс



		-Ажлын байр бүрийн гүйцэтгэх үүрэг, шаардлагатай чадамж тодорхой болж, байгууллагын бүтэц, зохион байгуулалт оновчлогдоно. Ажил олгогч, ажил хайгч хоёрын ойлголцол сайжирна -Хүний нөөц бүрдүүлэх, сонгон шалгаруулах үйл явц илүү оновчтой, ойлгомжтой болж, зөв хүн зөв ажилд очих боломж нэмэгдэнэ.	
Байгууллагын зорилго, үйл ажиллагааны чиглэлд нийцсэн гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтүүдийг (KPI) тодорхойлж, дараах байдлаар тогтмол хянах тогтолцоог бүрдүүлэх -KPI үзүүлэлтүүдийг чиг үүрэг, нэгжийн онцлогт тохируулан тодорхойлох -Үзүүлэлт бүрийн зорилтот түвшин (benchmark)-ийг тогтоох -Үр дүнг сар, улирал, жилийн хугацаанд үнэлэх	2025-2030 он	Удирдлага, хяналт-шинжилгээний тогтолцоо сайжирна -Ажлын гүйцэтгэл, үр дүнг тодорхойлох, үнэлэх нэг загвар, хэмжүүртэй болж, байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ үр дүнтэй болно. -Хэрэглэгчдэд үзүүлж буй үйлчилгээтэй холбоотой КР -Техникийн хяналт, засвар үйлчилгээтэй холбоотой KPI -Судалгаа, мэдээлэл, хяналтын системтэй холбоотой KPI	Захиргаа, удирдлагын хэлтэс




	-Үнэлгээнд үндэслэн дүн шинжилгээ хийж, сайжруулалтын арга хэмжээ боловсруулах -Гүйцэтгэлийн хяналтыг цахим системээр автоматжуулах боломжийг судалж хэрэгжүүлэх -KPI-ийн биелэлт, ахиц дэвшлийг байгууллагын удирдлагад тайлагнаж, ил тод байдлыг хангах		-Ажлын гүйцэтгэл ба байгууллагын дотоод хяналт KPI Тус бүр боловсруулагдаж үйл ажиллагааны үр дүнг үнэлэх боломжтой болно.	
	Байгууллагын үйл ажиллагаанд Lean Management буюу бережлив үйлдвэрлэлийн зарчмуудыг үе шаттайгаар нэвтрүүлж, илүүдэл процесс, хэрэгцээгүй хөдөлмөр, цаг хугацааны алдагдал, материаллаг болон зохион байгуулалтын хүлээлтийг бууруулах замаар үр ашгийг нэмэгдүүлэх -Илүүдэл үйлдэл, алдагдал, хүлээлтийг арилгах (Lean Manufacturing зарчмуудыг нэмэгдүүлэх) -Үйл явц бүрийн дотоод урсгалыг шинжлэн, илүүдэл	2025-2030 он	Ажиллагааны үр ашиг нэмэгдэнэ -Илүүц алхам, давхардсан үйлдлүүдийг халснаар ажил гүйцэтгэх хугацаа багасаж, бүтээмж нэмэгдэнэ. -Ажлын урсгал (workflow) илүү оновчтой, тасралтгүй болно. Зардал буурна -Түүхий эд, материалын алдагдал багасаж, хэрэглээ оновчлогдоно. -Ажиллах хүч, тоног төхөөрөмжийн ашиглалт сайжирч, нэмэлт зардал	Захиргаа, удирдлагын хэлтэс




	үйлдэл, шат дамжлагыг илрүүлэх “7 төрлийн алдагдал” (muda) -г тодорхойлох: 1. Илүүдэл үйлдвэрлэл 2. Хүлээлт 3. Тээвэрлэлт 4. Илүү хөдөлгөөн 5. Илүүдэл нөөц 6. Дахин боловсруулалт / гэмтэл 7. Үйлдвэрлэлд ашиглагдаагүй хүний чадвар		(илүү цаг, хэт их нөөц, засвар г.м.) буурна. Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж дээшилнэ -Бүтээгдэхүүн, үйлчилгээ хурдан, чанартай хүрдэг болсноор хэрэглэгчийн хүлээлт хангагдана. -Алдаа багатай, найдвартай бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлдэг болсноор нэр хүнд нэмэгдэнэ. Ажилчдын оролцоо, хариуцлага сайжирна • Ажилчид өөрсдөө ажлын орчныг сайжруулах санал, санаачилга гаргаж, хандлага эерэг болж, хамт олны соёл сайжирна. • Хөдөлмөрийн ачаалал зөв хуваарилагдаж, ажлын сэтгэл ханамж нэмэгдэнэ. Тасралтгүй сайжруулалт (Kaizen) хэрэгждэг болно • Үйл явцыг байнга хянаж, үнэлж, сайжруулах дадал тогтсон байна.
--	---	--	---




			Байгууллага өөрчлөлт, шинэчлэлд хурдан, уян хатан хандах чадвартай болно.	
	Байгууллагын бүх шатны үйл ажиллагаанд чанарын алдагдлыг бууруулж, процессын хэлбэлзлийг багасгах, тогтвортой, үр дүнтэй систем бүрдүүлэх зорилгоор олон улсын жишигт нийцсэн Six Sigma аргачлалыг үе шаттайгаар нэвтрүүлэх. Үүнд: -DMAIC аргачлал (Define – Measure – Analyze – Improve – Control) ашиглан аливаа асуудал, алдагдлыг илрүүлж, сайжруулалтын шийдэл боловсруулах -Чанарын ключ үзүүлэлтүүд (Critical to Quality – CTQ)-ийг тодорхойлж, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг судлах -Процессын гүйцэтгэлийг шинжилгээ, статистик	2025-2030 он	Чанарын алдагдал эрс багасна - Алдаа, гологдол, буцаалт зэрэг чанарын доголдлуудыг тоон хэмжүүр дээр тулгуурлан илрүүлж, үндсээр нь шийдвэрлэнэ. - Үйл ажиллагаа бүрд өндөр нарийвчлал, тогтвортой байдал бий болно. Процессын хэлбэлзэл буурна - Статистик аргачлалаар процессыг хянаж, хэлбэлзлийг хэмжих, удирдах боломжтой болно. - Хэмжиж болохуйц, тоон үзүүлэлтээр хянагддаг систем бүрдэж, тогтвортой байдал хангагдана. Шийдвэр гаргалт тоон мэдээлэлд тулгуурлана - Санамсаргүй шийдвэрүүд багасаж, өгөгдөлд суурилсан оновчтой менежмент нэвтэрнэ.	Захиргаа, удирдлагын хэлтэс Санхүүгийн алба Мэдээлэл технологийн хэлтэс



	аргачлалаар нарийвчлан үнэлэх -Дата-д суурилсан шийдвэр гаргалтыг сайжруулж, хүний алдаа, хэлбэлзлийг бууруулах -Үйл ажиллагааг 0–3.4 ppm (1 сая тутамд 3.4 алдаа) хүртэл бууруулах зорилготойгоор стандарт тогтоох -Six Sigma сургалт, чадамжийн түвшин (White, Yellow, Green Belt)-ийн сургалтуудыг зохион байгуулах -Сайжруулалтын төслүүдийг тодорхойлж, төсөл бүрийн өгөөж, нөлөөллийг хянах тогтолцоо бий болгох -Тасралтгүй сайжруулалт, өгөгдөлд тулгуурласан шийдвэр гаргалтын соёлыг төлөвшүүлэх		- Эрсдэлийг бодитоор үнэлэх, удирдах чадвар дээшилнэ. Үр дүнд суурилсан соёл бүрдэнэ - Байгууллагын соёл үр дүнд төвлөрсөн, тасралтгүй сайжруулалтыг эрхэмлэдэг болдог. "Алдаа гаргах биш, сайжруулах боломж" гэсэн хандлага төлөвшдөг. Олон улсын түвшний менежмент, өрсөлдөх чадвар - Байгууллага нь олон улсын стандарт, хүлээн зөвшөөрөгдсөн аргачлалаар үйл ажиллагаагаа удирдаж, глобал түншлэл, хөрөнгө оруулалт татахад илүү давуу байдалтай болно. Чанар тогтвортой байдлыг нэмэгдүүлэх (Six Sigma) аргачлал нэвтрүүлснээр байгууллагын чанар, аюулгүй байдал, хэрэглэгчийн сэтгэл ханамж, зардлын оновчтой байдал зэрэгт шууд эерэг нөлөө үзүүлнэ.	
	Байгууллагын үйл ажиллагааны бодит мэдээлэлд суурилсан	2025-2030 он	Лот болон дата анализ ашиглан шийдвэр гаргалтыг үндэслэлтэй болгосноор байгууллагын ерсдэлийн удирдлага,	Захиргаа, удирдлагын хэлтэс



	хяналт, төлөвлөлт, шийдвэр гаргалтыг сайжруулах зорилгоор Интернэтийн зүйлс (IoT) болон өгөгдлийн шинжилгээний (Data Analytics) технологийг үе шаттайгаар нэвтрүүлж, ашиглалтыг өргөжүүлнэ. Үүнд: -IoT төхөөрөмжүүд (угаар мэдрэгч, зуухны хяналтын систем, хийн даралт хэмжигч гэх мэт) ашиглан бодит цагийн өгөгдөл цуглуулах -Цугларсан өгөгдөлд статистик шинжилгээ болон чанарын үнэлгээ хийх замаар: ○ Эрсдэл үүсэх нөхцөлийг урьдчилан илрүүлэх ○ Хэрэглээний хэв маяг, ачааллын өөрчлөлтүүдийг таних ○ Засвар үйлчилгээний урьдчилсан төлөвлөлт хийх -Том өгөгдлийн (Big Data) менежмент, AI-д суурилсан		нөөцийн оновчлол, стратегийн төлөвлөлт, иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар зэргийг шинжлэх ухаанч үндэслэлтэйгээр сайжруулах үйл явц хэрэгжинэ. Үйл ажиллагааны бодит цагийн хяналт сайжирна • IoT төхөөрөмжүүдийн тусламжтайгаар тоног төхөөрөмж, процессуудын үйл ажиллагааг бодит цагт хянах боломжтой болно. • Аливаа доголдол, зогсолт үүсэхээс өмнө урьдчилан мэдэгдэж, түргэн арга хэмжээ авах боломж бүрдэнэ. Үр ашиг, бүтээмж нэмэгдэнэ • Өгөгдлийн шинжилгээ ашиглан процессын үр ашгийг үнэлж, оновчтой төлөвлөлт хийхэд тусална. • Үйл ажиллагааны гажуудал, нөөцийн илүүдэл зэргийг илрүүлэн, тасралтгүй сайжруулалт хийхэд дэмжлэг болно. Шийдвэр гаргалт оновчтой болно	Санхүүгийн алба Мэдээлэл технологийн хэлтэс
--	--	--	--	---



	тайлагнал ашиглан удирдлагад уншигдахуйц, бодит мэдээллийн бааз үүсгэх - Мэдээллийн урсгалыг төвлөрүүлэх дата платформ (data lake / data warehouse) бүрдүүлж, тайлан боловсруулалт, дүрслэл (data visualization) хийх - Шийдвэр гаргагчдыг өгөгдөлд суурилсан хандлагаар сургах, аналитик соёлыг төлөвшүүлэх		- Том өгөгдөл, аналитик аргуудыг ашиглан байгууллагын гүн гүнзгий ойлголт бий болгоно. - Урьдчилан таамаглах, эрсдэлийг тооцох чадвар нэмэгдэж, стратеги төлөвлөлт, хурдан шийдвэр гаргах боломжтой болно.	
	Байгууллагын үйл ажиллагааны чанар, хэрэглэгчийн сэтгэл ханамж, дотоод процессын тогтвортой сайжруулалтыг хангах зорилгоор олон улсын ISO 9001: Чанарын удирдлагын тогтолцоо (QMS)-г үе шаттайгаар нэвтрүүлж, хэрэгжүүлнэ. -Байгууллагын үйл ажиллагааг ISO 9001:2015	2025-2030 он	Энэхүү тогтолцоо нь байгууллагын чанарт суурилсан соёл төлөвшүүлэх, дотоод хяналтыг сайжруулах, иргэдэд хүргэх үйлчилгээг тогтворжуулах, олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдөх үндэс суурийг бүрдүүлнэ. Үйл ажиллагааны тогтвортой байдал нэмэгдэнэ Процессууд стандартад нийцсэн тогтвортой системд шилжих тул гэнэтийн алдаа, доголдол багасна.	Захиргаа, удирдлагын хэлтэс Санхүүгийн алба



	стандартад үнэлэх, тодорхойлох нийцүүлэн зөрчлийг -Чанарын зорилго, бодлого тодорхойлон, удирдлагын амлалт гаргах -Үйл ажиллагааны процессуудыг зураглаж, баримтжуулсан стандарт ажиллагааны журам (САЖ) боловсруулах -Эрсдэлийн удирдлага, боломжийн үнэлгээний систем бүрдүүлэх -Дотоод аудитын тогтолцоо бүрдүүлж, хэрэгжилт, зөрчлийг тогтмол хянах -Ажилтнуудад ISO сургалт, ойлголт олгох хөтөлбөр хэрэгжүүлэх -Сэтгэл ханамжийн судалгаа, өгөгдөлд		- Хяналт, хариуцлагын тогтолцоо бэхжиж, ажлын гүйцэтгэл тогтмол сайжирна. Дотоод процессууд ил тод, уялдаа холбоотой болно - Процессуудыг бичиг баримтаар баталгаажуулж, харилцан уялдуулах замаар үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлнэ. - Алдаа, давхардал, мэдээллийн зөрүү багасан, хариуцлага тодорхой болно. Тасралтгүй сайжруулалтын соёл төлөвшинө - QMS-ийн дагуу байнга дүн шинжилгээ хийж, алдаа дутагдлаа илрүүлэн сайжруулах явц тогтсон хэвшил болно. - Ажилчдын оролцоо, санаачилга нэмэгдэж, байгууллагын бүтээмж өснө. Хууль, дүрэм журмыг бүрэн мөрддөг болно - Чанарын удирдлагын тогтолцооны дагуу холбогдох стандарт, хууль эрх	
--	---	--	--	--



	суурилсан сайжруулалтын шийдвэр гаргах -ISO 9001 стандартын дагуу гэрчилгээ авах төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг гүйцэт хянах		зүйн шаардлагыг бүрэн хангаж ажиллана. - Зөрчил, торгууль, алдаанаас сэргийлнэ. Байгууллагын нэр хүнд, өрсөлдөх чадвар сайжирна - Олон улсын стандарт хангасан QMS нь харилцагч, түншүүдийн итгэл нэмэгдэж, шинэ зах зээлд орох боломжийг өргөжүүлнэ. - Хөрөнгө оруулалт татах, гэрээ байгуулахад давуу тал болно. Тасралтгүй сайжруулалтын соёл төлөвшинө - QMS-ийн дагуу байнга дүн шинжилгээ хийж, алдаа дутагдлаа илрүүлэн сайжруулах явц тогтсон хэвшил болно. - Ажилчдын оролцоо, санаачилга нэмэгдэж, байгууллагын бүтээмж өснө.	
	Үйлдвэрийн газрын үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх, сургалтын чанар, хяналт, үнэлгээг сайжруулах,	2025-2030 он	Үйлдвэрийн үйл ажиллагааны бүтээмж нэмэгдэнэ Сургалт, хяналт, үнэлгээний систем сайжирснаар ажиллах процесс	Захиргаа, удирдлагын хэлтэс Санхүүгийн алба




	-Хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан нэгжийг хөгжүүлэх Эрсдэлийн үнэлгээ, судалгааг тогтмолжуулах		оновчтой болж, хугацаа, зардал багасна. - Алдаа, үйлдвэрлэлийн доголдол буурч, бүтээгдэхүүний чанар сайжирна. Хяналт, үнэлгээний ил тод, тогтвортой тогтолцоо бий болно - Үйл ажиллагааны бүх шатанд хяналт сайжирч, гүйцэтгэл тогтмол үнэлэгдэж, алдаа дутагдлыг хурдан илрүүлнэ. - Үр дүнтэй шийдвэр гаргах суурь бий болно.	Мэдээлэл технологийн хэлтэс 9025040608 7140793 7140793
ЗОРИЛТ 2. МЭДЭЭЛЛИЙН ДЭД БҮТЭЦ, ТЕХНИК ХАНГАМЖИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ,	Одоогийн нөхцөл байдлын үнэлгээ (IT Audit) хийх -Сервер, сүлжээ, компьютерын хүчин чадал, ачаалал, ашиглалтын хугацааг үнэлэх -Программ хангамжийн лиценз, хууль ёсны ашиглалтын байдлыг шалгах -Аюулгүй байдлын сул талууд илрүүлэх	2025-2030 он	Тоо баримт дээр суурилсан шийдвэр, гаргах, зөвлөмж өгөх Мэдээллийн хурд, хүртээмж сайжирна - Өгөгдөл дамжуулах хурд нэмэгдэж, байгууллагын бүх салбар, хэлтэс, ажилтнуудад мэдээлэл шуурхай хүрнэ. - Олон хэрэглэгч нэгэн зэрэг системд ачаалал багатай нэвтрэх боломжтой болно.	Мэдээлэл технологийн хэлтэс IT нэгж




	-Сүлжээний хурд, тогтвортой байдал, өргөтгөх боломжийг судлах -Сервер, сүлжээний дэд бүтцийг сайжруулах Техник хангамжийг шинэчлэх, стандартад нийцүүлэх -Ажилтнуудын компьютер, тоног төхөөрөмжийн хүчин чадлыг сайжруулах (RAM, SSD, CPU) -Хэвлэх, скан хийх төхөөрөмжүүдийг сүлжээний шийдэлтэй, хяналттай болгох -Төхөөрөмж бүрийг asset management системд бүртгэх (инвентар хөтлөх) -Цахим хэрэглээний цаг ашиглалт, хяналтын шийдэл (endpoint management) нэвтрүүлэх		Үйл ажиллагааны найдвартай байдал нэмэгдэнэ - Техник тоног төхөөрөмж, сервер, сүлжээний шинэчлэлт, засвар үйлчилгээ сайжрах замаар системийн тасралтгүй ажиллагаа хангагдана. - Гэнэтийн доголдол, алдаа багасан, мэдээллийн алдагдал үүсэх эрсдэл буурна. Аюулгүй байдал сайжирна - Орчин үеийн техник хангамж, сүлжээний хамгаалалтын шийдлүүд нэвтэрснээр мэдээллийн аюулгүй байдал, хакердах, алдагдах эрсдэл буурна. - Нууцлал, хандах эрхийн зохистой менежмент сайжирна. Мэдээллийн нэгдсэн удирдлага бий болно - Олон янзын систем, платформуудыг уялдуулах, нэгтгэх боломж нэмэгдэж, мэдээллийн давхардал багасна.	
--	---	--	---	--



	Программ хангамжийг оновчтой болгох -Лицензтэй, албан ёсны программ ашиглах (Microsoft, Adobe гэх мэт) -ERP, CRM, HR систем зэрэг ажлын урсгалыг нэгтгэсэн шийдлүүд нэвтрүүлэх -Өгөгдөл удирдах, тайлан боловсруулах BI систем (Power BI, Tableau) ашиглах -Ажилтнуудын онлайн хамтын ажиллагааны платформ (Microsoft 365, Google Workspace) нэвтрүүлэх Цахим шилжилт ба автоматжуулалт -Ажил гүйцэтгэлийн төлөвлөлт, хяналт, тайлагналын систем нэвтрүүлэх (жишээ: Asana, Trello, Jira)		• Менежерүүдийн шийдвэр гаргах үйл явцад бодитой, нарийвчилсан өгөгдөл ашиглагдана. Шинэлэг технологи нэвтрүүлэх суурь бэлдэх • Их өгөгдөл (Big Data), хиймэл оюун ухаан (AI), Интернэт зүйлс (IoT) зэрэг шинэ технологийг үр дүнтэй ашиглах боломж бүрдэнэ. • Цаашдын дижитал шилжилт амжилттай явагдана. Зардал багасан, хөрөнгө оруулалт үр дүнтэй болно • Техникийн доголдол, алдаа багассанаар засвар үйлчилгээний зардал буурна. • Шинэ системийн үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлснээр зардлын хэмнэлт гарна. Ажилчдын бүтээмж, сэтгэл ханамж нэмэгдэнэ • Техник хангамжийн тасралтгүй ажиллагаа, хурдан ажиллагаа нь ажилчдын өдөр тутмын ажлыг
--	--	--	--




	-Цахим архив, бичиг баримтын удирдлагын систем (DMS) ашиглах -Хүний оролцоог багасгах автоматжуулсан шийдлүүд хэрэгжүүлэх -Цахим гарын үсэг, дижитал баталгаажуулалт нэвтрүүлэх		хөнгөвчилж, сэтгэл ханамж сайжирна. Хэрэглэгчдэд үйлчилгээ үзүүлэх үйл явц хурдан, найдвартай болно.	
	Ослын дата бүртгэх систем нэвтрүүлэх -Хордлогын тохиолдолд орчны шинжилгээ хийх аргачлал боловсруулах (орчин нөхцөл, галлагааны арга, түлшний төрөл, зуухны төрөл) -Шалтгаан дээр суурилсан зөвлөмжийн төрлүүдийг боловсруулах -Хяналт, тохиргоо хийх багийн аргачлал боловсруулах	2025-2030 он	Ослын тохиолдлыг нарийвчлан бүртгэн, шинжилж чадна - Бүх ослын мэдээллийг төвлөрүүлэн нэгтгэх тул асуудлын шалтгааныг тодорхойлох, давтагдлыг илрүүлэхэд дөхөм болно. - Үнэн зөв, бүрэн мэдээлэлтэй тулгасан шийдвэр гаргалт хийнэ. Осол, гэмтлийн давтамж буурна - Ослын шалтгааныг тодорхойлж, эрсдэлийг урьдчилан тогтоон сэргийлэх арга хэмжээг эрт авах боломжтой болно. - Хяналт, сургалт, аюулгүй ажиллагааны сайжруулалт үр дүнтэй болно.	




	Технологид хяналтын өргөжүүлэх суурилсан системийг Үзүүлэлт сайтай угаар мэдрэгч төхөөрөмжийн нийлүүлэлтийг хангах -Ухаалаг төхөөрөмж ашиглах: Угаарын хий мэдрэгч төхөөрөмжүүдийг IoT (Интернэтэд холбогдсон зүйлс) системтэй холбож, төвлөрсөн хяналтын төвтэй болгох. -Мэдээллийн нэгдсэн систем: -Яндан, зуухны бүртгэлийн системийг боловсронгуй болгох Айл өрхүүдийн яндан, зуухны байдал, хий алдалтын түүхийг бүртгэдэг мэдээллийн сантай болох. -Төхөөрөмжүүдийг хяналтын нэгдсэн дата системтэй болгох	2025-2030 он	Алдаа, осол, гажуудлын эрсдэл багасна - Автомат хяналт осол, алдааны шалтгааныг шууд мэдээлж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах боломжийг бүрдүүлнэ. - Аюулгүй ажиллагаа сайжирч, ажилтны эрсдэл буурна. Аюулгүй байдал сайжирна - Ажилтнууд аюулгүй ажиллагааны дүрэм, зааврыг илүү сайн мэдэж, мөрдөх тул осол гэмтэл багасна. - Эрсдэлээс урьдчилан сэргийлэх боломж нэмэгдэнэ.	Мэдээлэл технологийн хэлтэс IT нэгж
--	---	---------------------	---	---




	Угаар мэдрэгчийг ухаалаг хяналтын системд холбох -Хэрэглэгчдийн эрсдэлийн үнэлгээний аргачлал боловсруулах Техник, тоног төхөөрөмжийн хүртээмж нэмэгдүүлэх Ажилтнуудыг угаар мэдрэгч, СО хэмжигч, амьсгалын баг, анхан шатны тусламжийн багц-аар хангах. Мэдрэгч төхөөрөмжийн суурилуулалт ба шалгалтыг протоколын дагуу хийх.			
ЗОРИЛТ 3. САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН НЭГДСЭН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ	-Салбарын хүний нөөцийн нэгдсэн бодлогыг боловсруулах	2025-2030 он	Салбарын хэмжээнд хүний нөөцийг чадавхжуулах, мэргэшүүлэх сургалтын нэгдсэн бодлого, үйл ажиллагаа сургалт, судалгааны үйл ажиллагаа хэрэгжинэ.	Сургалт, судалгаа, дүн шинжилгээний нэгж Бусад сургалтын мэргэжлийн байгууллага
	Тэргүүлэх, зөвлөх инженерүүдийг чадамж хослуулж ашиглах чадамжийн үнэлгээний ажилтнаар бэлтгэх	2025-2030 он	Хүний нөөцийн удирдлага сайжирна Ажилтнуудын элсэлт, сурталчилгаа, сургалт, үнэлгээ, урамшууллын үйл	




-Техник, технологийн ажилтан ба мэргэжлийн ажилтан бэлтгэх болон үйлдвэрлэлийн дадлага хийх гуравласан гэрээ байгуулах ажлыг зохион байгуулж чиглүүлэх, үр дүнг тооцох			ажиллагаа нэгтгэгдэн илүү системтэй, оновчтой болно. Хүний нөөцийн нөөцтэй холбоотой шийдвэр гаргалт уялдсан, төлөвлөгөөтэй болно.	
Салбарын хүний нөөцийн сургалтын хэрэгцээг тодорхойлох судалгааг хийх			Чадавхыг оновчтой хөгжүүлнэ	
-Салбарын хүний нөөцийн сургалтын тогтвортой үйл ажиллагаа явуулах, эргэх холбоог бий болгох тогтолцоог бүрдүүлэх			- Салбарын хэмжээнд шаардлагатай ур чадвар, мэдлэгийг тодорхойлж, холбогдох сургалт, хөгжлийн хөтөлбөрүүдийг зохион байгуулна. - Мэргэжлийн чадавхыг нэг түвшинд хүргэх, тогтвортой сайжруулах боломжтой болно.	
-Салбарын ажилтан, ажилчдыг үе шаттай сургалтад хамрагдах нөхцөлийг бүрдүүлж, суралцагчдын судалгааг жил бүр шинэчлэн гаргах, мэдээллийн нэгдсэн санд байршуулах. -Сургалтын дэд бүтцийг оновчтой ашиглах			Ажилтан бүрийн мэргэшил дээшилж, ажиллах чадвар нэмэгдэнэ - Сургалтын чанар сайжирснаар ажилчдын мэдлэг, ур чадвар баталгаатай дээшилж, ажлын гүйцэтгэл сайжирна. - Хариуцлагатай, чадавхтай боловсон хүчин бүрдэнэ. Сургалт, хөгжил зорилтот, үр дүнтэй болно	
-Салбарын хүний нөөцийг бүхэлд нь чадавхжуулах чадамжид суурилсан сургалтын		2025-2030 он	Сургалтын хөтөлбөрүүд стандартад нийцсэн, үр дүнтэй хэлбэрээр	




	хөтөлбөр, загвар боловсруулах, -Үйлдвэрийн газрын инженер, техникийн ажилтнуудад зориулсан чадамжид суурилсан тусгайлсан сургалтын хөтөлбөрийг мэргэжлийн байгууллагатай хамтран боловсруулах -Сургалтын хэрэглэгдэхүүн, материал хангамжийг орчин үеийн шаардлагад нийцүүлэх арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэх -Сургалтын шинэлэг арга, техникүүдийг нэвтрүүлэх Сургалтын үр дүнгийн үнэлгээний аргачлал боловсруулах		хөгжиж, ажилтныг шат дараатай мэргэшүүлэх боломж бүрдэнэ. Ажилтан солигдол багасч, тогтвортой байдал нэмэгдэнэ • Нэгдсэн бодлогын хүрээнд ажилтнуудын сэтгэл ханамжийг дээшлүүлэх, урамшуулал, хөгжлийн боломжийг жигд хангах замаар ажиллах орчин сайжирна. • Ажилтан хадгалах, тогтвортой баг бүрдүүлэх суурь болно. Төрийн бодлого, хууль эрх зүйн шаардлагуудыг бүрэн хангана • Салбарын хүний нөөцийн бодлого нь холбогдох хууль, дүрэм журмыг нэгтгэн хэрэгжүүлж, зөрчил дутагдалгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ. Үйл ажиллагааны уялдаа холбоо сайжирна • Салбарын бүхий л байгууллагуудын хүний нөөцийн үйл ажиллагаа уялдаатай, жигд явагдаж, дотоод зөрчил багасна.
--	---	--	---




			- Мэдээлэл харилцан солилцох, хамтын ажиллагаа сайжрахад дөхөм болно. Хүний нөөцийн төлөвлөлт илүү үр дүнтэй болно - Ирээдүйн шаардлага, салбарын хөгжлийн чиг хандлагад нийцсэн хүний нөөцийн урт хугацааны төлөвлөгөө боловсруулах боломж бүрдэнэ. - Хүний нөөцийн дутагдал, илүүдлийг эрт илрүүлэн зохистой зохицуулалт хийх суурь болно.	
	Хяналт, хариуцлагын механизм бий болгох Шалгалт, дүгнэлт гаргах журам боловсруулж хэрэгжүүлэх: Ажилтнууд хийсэн ажлынхаа дараа шалгагдах боломжтой байхаар баримтжуулалт, тайлангийн тогтолцоо бүрдүүлэх. Үүрэг хариуцлагын гэрээ: Ажилтантай тодорхой хариуцлагын заалт бүхий гэрээ байгуулж, аюулгүй ажиллагааг	2025-2030 он	Ажлын сахилга бат, хариуцлага нэмэгдэнэ - Ажилтан бүрийн үүрэг, хариуцлага тодорхой болж, хийсэн ажлынхаа үр дүнд хариуцлага хүлээдэг тогтолцоо бий болно. - Алдаа гаргасан тохиолдолд хариуцлага тооцогддог, харин сайн гүйцэтгэл урамшуулдаг шударга орчин бүрдэнэ. Алдаа, зөрчил, хариуцлагагүй байдал буурна	Сургалт, судалгаа, дүн шинжилгээний нэгж Бусад сургалтын мэргэжлийн байгууллага




	хангагүй тохиолдолд хариуцлага тооцох заалт оруулах. Гүйцэтгэлийн үнэлгээтэй уялдуулах: Аюулгүй ажиллагаа, иргэдэд зөв заавар өгсөн байдал зэргийг улирал бүр үнэлж, шагнал урамшуулал, цалинтай холбох.		Хяналтын системийн тусламжтайгаар гүйцэтгэл тогтмол хянагдаж, алдааг эрт илрүүлэн засварлах боломжтой болно.	
	Хувь хүний хөгжлийг дэмжих: -Ажиллагсдын хөдөлмөрлөх хандлагыг нэмэгдүүлэх, хувь хүний хөгжлийн сургалтуудыг тогтмол зохион байгуулах	2025-2030 он	Хөдөлмөрийн бүтээмж нэмэгдэнэ - Ажилтнууд ажилдаа илүү идэвхтэй, хариуцлагатай хандаж, ажлын үр дүн нь мэдэгдэхүйц сайжирна. "Би чухал хүн" гэсэн мэдрэмж төрүүлж, ажилдаа эзэнтэй болох хандлага төлөвшинө. Сэтгэл ханамж, урам зориг нэмэгдэнэ - Хувь хүний хөгжлийг дэмжсэн сургалт нь ажилтныг хүндэлж, хөгжүүлэхэд анхаарч байгаагийн илэрхийлэл болж, сэтгэл ханамж дээшилнэ. - Сургалтын үр дүнд өөртөө итгэх итгэл, өөрийгөө илэрхийлэх чадвар, харилцаа сайжирна.	




			Ажилтны тогтвор суурьшил сайжирна • Сургалт, хөгжлийн тогтвортой бодлоготой байгууллагад ажилтнууд илүү удаан, тууштай ажиллах хандлагатай болдог. • Ажиллах орчны сэтгэл ханамж, үнэнч байдал нэмэгдэж, ажлаас гарах урсгал буурна. Багаар ажиллах чадвар, харилцаа сайжирна • Хувь хүний хөгжлийн сургалтаар дамжуулан хамт олонтойгоо үр дүнтэй харилцах, хамтран ажиллах, сэтгэл зүйгээр дэмжих хандлага төлөвшинө. • Дотоод уур амьсгал эерэг болж, бүтээлч хамтын ажиллагаа бий болно.	
Байгууллагын хамгааллын хэрэгжүүлнэ.	хүүхэд бодлогын	2025-2030 он	МУ-ын төрөөс хүүхэд хамгааллын бодлогыг салбар дундын оролцоонд тулгуурлаж хэрэгжүүлэхэд аж ахуйн нэгжийн үүргээ биелүүлнэ. Ажил үүргээ гүйцэтгэх явцад хүүхэд хамгаалалд анхаарах боломжтой болно.	Сургалт, судалгаа, дүн шинжилгээний нэгж Бусад сургалтын мэргэжлийн байгууллага




	-Ажилтнуудын хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх, -Ажилтнуудаа хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэгч, үүрэг хүлээгч байхад бэлтгэх,		Ажилтан хүүхэдтэй холбоотой эрсдэлийг таньж, зохих ёсоор мэдээлэх чадамжтай болно. Ажилтан хүүхдэд хүндэтгэлтэй, эерэг хандлагаар хандаж, үлгэр дуурайлал үзүүлэх мэдлэгтэй болно. Ажилтан өөрийн хүүхдээ хамгаалах, эрхийг нь ойлгох, эерэг аргаар хүмүүжүүлэх ойлголт мэдлэгтэй болно.	
	Хөдөлмөрийн аюулгүй байдал сэтгэл ханамжид анхаарах Компани өөрөө зөв үлгэрлэх: Байгууллагын машинд угаар мэдрэгчтэй эсэх, оффист агааржуулалт хангалттай эсэх зэргийг шалгаж, бусдад үлгэрлэх. -Төр, хувийн хэвшил, олон нийтийн хамтын ажиллагааг сургалтын үйл ажиллагаанд хангах -Үйлдвэрлэлийн дадлагажуулагч багш болон өөрийн гэрээт сургагч багш нартай болох	2025-2030 он	Ажлын байрны аюулгүй байдал сайжирч, осол гэмтэл буурна • Аюулгүй, эрүүл орчин бүрдсэнээр осол, гэмтэл, эрүүл мэндийн эрсдэл буурна. • Эрүүл, аюулгүй ажиллах нөхцөл бүрдсэн нь ажилтны ажиллах чадвар, идэвхийг нэмэгдүүлдэг Сургалтыг үр дүнтэй тогтмол, тогтсон хөтөлбөрөөр явуулах боломж бүрдэнэ.	




	Мэргэшсэн хүний нөөцийг тогтвортой ажиллуулах урамшууллын тогтолцоог бүрдүүлэх Ажиллагсдын сэтгэл ханамжийн судалгааны аргачлалтай болох Ажиллагсдын сэтгэл ханамжийн судалгааг тогтмол явуулах		Хариуцлагатай ажилласан ажилтныг шагнах: Иргэдээс талархал ирсэн, угаар мэдрэгч суурилуулалт бүрэн хийсэн, осолгүй улирал ажилласан ажилтнуудыг мөнгөн шагнал, урамшууллаар шагнах. Зөрчил гаргасан тохиолдолд арга хэмжээ авах: Аюулгүй ажиллагааг үл тоомсорлосон бол сануулах, торгох, дахин сургалтад хамруулах гэх мэт шат дараалсан хариуцлага тооцох. Ажлын байрны соёл, ёс зүй төлөвшинө Сургалт нь ёс зүй, хариуцлага, цаг баримтлах, харилцааны соёл зэрэг зан үйлийг төлөвшүүлж, байгууллагын соёлын суурийг бий болгоно.	
ЗОРИЛТ ХЭРЭГЛЭГЧИЙН БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ, СИСТЕМТЭЙ	4. -Түлш зуух галлагааны талаар стандарт боловсруулах -Стандарт галлагааны зөвлөмж боловсруулах	2025-2030 он	Галлах үйлдлийг стандартчилах, ослын магадлалыг бууруулах боломж бүрдэнэ.	Сургалт, судалгаа, дүн шинжилгээний нэгж Бусад сургалтын




ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ	-Хэрэглэгчийн түлш ашиглалт, угаар мэдрэгчийн талаарх мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх сургалтын хөтөлбөр боловсруулах -Хэрэглэгчдэд зориулсан богино хугацааны сургалт, зөвлөгөөг тогтмолжуулах -Ахуйн хэрэглэгчдэд зориулсан жишиг хэрэглээний заавар түгээх -Хэрэглэгчдэд зориулсан мобайл апп эсвэл вэб портал ажиллуулах: түлшний зөв хэрэглээ, осол мэдэгдэх, зөвлөгөө авах боломжтой Орчны нөхцөлд тохирсон зааварчилгаа боловсруулах: -Видео, постер, гарын авлага бэлдэж олон нийтийн сүлжээгээр түгээх -Сайжруулсан зуухны жагсаалт гаргах		Угаарын хийд хордож, эрсдэлд өртөх тохиолдол мэдэгдэхүйц буурна • Зөв галлагаа, аюулгүй хэрэглээ, агааржуулалтын талаар мэдлэгтэй хэрэглэгч осолд өртөх эрсдэлээс сэргийлж чаддаг. • Угаарын хийн аюулыг ухамсарласан иргэн эрт сэрэмжилж, буруу хэрэглээнээс татгалздаг. Шахмал түлшний зөв хэрэглээ нэмэгдэж, үр ашиг сайжирна • Зөв галласнаар түлш бага зарцуулагдаж, дулаан их өгч, гэр бүлд эдийн засгийн хэмнэлт гарна. • Бүтээгдэхүүний нэр хүнд, хэрэглэгчийн итгэл нэмэгдэнэ. Агаарын бохирдлыг бууруулахад бодит хувь нэмэр оруулна • Иргэд зөв хэрэглэж эхэлснээр яндангийн утаа багасч, хөрсний болон агаарын бохирдол буурна. • Түгээмэл буруу хэрэглээнээс үүдэлтэй утаа, хорт утаа, тортог багасна.	мэргэжлийн байгууллага
--	--	--	--	-------------------------------




	-Галлах дараалал, зуухны амны байршил, агаартай харьцах нөхцөл -Түлш хадгалах нөхцөл, чийгтэй түлшний танилцуулга гэх мэт		Иргэдийн хандлага, хариуцлага сайжирна • Сургалт, зөвлөмжийн үр дүнд хэрэглэгч өөрийн аюулгүй байдалд хариуцлагатай хандаж, бусдад зөв нөлөө үзүүлдэг. • Системтэй мэдээлэлтэй хэрэглэгчдийн тоо нэмэгдэх тусам буруу хэрэглээг засах орчны соёл төлөвшинө. Осол, гомдол, сөрөг мэдээлэл буурна • Иргэд мэдлэгтэй болж, мэдээлэлтэй шийдвэр гаргах чадвар нь нэмэгдсэнээр осол, гомдол, маргаан багасна. • Олон нийтийн сүлжээнд шахмал түлштэй холбоотой сөрөг сэтгэгдэл багасч, олон нийтийн ойлголт сайжирна. Угаар мэдрэгч төхөөрөмжийн хэрэглээ, үр ашиг нэмэгдэнэ • Сургалтаар төхөөрөмжийг зөв суурилуулах, ажиллуулах заавар өгснөөр хэрэглээний алдаа багасна.
--	---	--	---




			- Төхөөрөмжийн үр дүн сайжирч, эрсдэлийг илүү үр дүнтэй хянах нөхцөл бүрдэнэ. Төр-иргэн-хувийн хэвшлийн уялдаа сайжирна - Иргэдтэй шууд харилцсан боловсролын хөтөлбөр нь нийгмийн оролцоог нэмэгдүүлж, хамтдаа эрсдэлийг бууруулах уур амьсгалыг бүрдүүлнэ. - Сургагч багш, хорооны ажилтан, мэргэжлийн хяналт, хэрэглэгчдийн хамтын ажиллагаа сайжирна.	
	Нээлттэй мэдээлэл, олон нийтийн дэмжлэгийг нэмэгдүүлэх -Иргэдийн санал, гомдол ослын тохиолдлыг бүртгэх систем (call center, app, QR кодоор санал авах гэх мэт) -Гэрт нь очиж үзүүлэх сургалт “Жишиг зуух яаж галлах вэ? практик заавар хэрэгжүүлэх	2025-2030 он	Иргэд өөрсдөө таньж мэддэг, шалгадаг, шийдвэр гаргадаг болно. Мэдрэгч байгаа ч үүргээ биелүүлж байгаа эсэхийг баталгаажуулах сануулга бий болно. Орон нутгийн түвшинд мэдээлэл хүргэх суваг нэмэгдэж хамтын хариуцлага дээшилнэ. Иргэд хоорондоо хариуцлага итгэлцэлтэй болно.	Сургалт, судалгаа, дүн шинжилгээний нэгж Бусад сургалтын мэргэжлийн байгууллага




	-Угаарын хийн эрсдэл, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх -Угаар мэдрэгчийг зөв ашиглах, хяналт тавих дадлыг олгох -Аюулгүй ажиллагааны дүрэм журмыг мөрдөх ухамсрыг төлөвшүүлэх -Дүүрэг, хороо, сургууль, эмнэлгийн нийгмийн ажилтнууд, хорооны эмч нарыг урьдчилан сэргийлэх мэдээлэл түгээхэд сайн дурын оролцогчоор чадавхжуулах -Сайн туршлагыг сурталчлах угаар мэдрэгч аварсан тохиолдлуудыг нийтэлж урам өгөх -Видео, контент хичээлүүд бэлтгэн түгээх: Яндангийн аюулгүй байдал, зөв галлагаа, угаар мэдрэгч ашиглалт зэргээр олон			
--	--	--	--	--




	нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх. -Сургууль, цэцэрлэгтэй хамтрах: Ирээдүйн хэрэглэгчдийг багаас нь ухамсарлуулах сургалтууд зохион байгуулах.			
	-Нийтлэг уриатай нэгдсэн кампанит ажил -“Мэдрэгч шалгах аян” хэрэгжүүлэх -“Сануулах мессеж аян” -Сайн дурын “гэрийн аюулгүй байдлын элч” бэлтгэх (Тухайн хорооноос, гэр бүлээс нь үүрэг хүлээсэн иргэнийг сонгож сургалтад суулгаж гэрчилгээ олгох) -“Хөршөө хамгаалъя” уриатай аян угаарын дохиог сонсвол дуудлага өгөх сэтгэл зүйг бий болгох -“Надад туслаарай” мэдээллийн чатбот хөгжүүлэх	2025-2030 он	Иргэдийн анхаарал, оролцоо нэмэгдэнэ • Нийтлэг уриа, тодорхой зорилготой кампанит ажил олон нийтийн анхаарлыг нэг чигт төвлөрүүлж, мэдээллийг илүү үр дүнтэй түгээнэ. • Иргэд өөрсдийгөө хамтдаа нэг зорилгын төлөө ажиллаж байна гэж мэдэрч, идэвхтэй оролцох хандлагатай болно. Мэдээлэл түгээлт, ойлголт уялдаа сайжирна • Хүн бүрд ижил агуулгатай, ойлгомжтой уриа хүрэх нь мэдээллийн зөрүү, буруу ойлголтыг багасгаж, зөв дадал, зан үйл төлөвшүүлнэ. • Тухайн сэдвийн талаарх олон нийтийн нийтлэг ойлголт нэмэгдэж,	Сургалт, судалгаа, дүн шинжилгээний нэгж Бусад сургалтын мэргэжлийн байгууллага




	-“Яндан цэвэрлэгээний хөтөлбөр” хэрхэн хэдэн сард нэг удаа цэвэрлэх вэ?		тархай бутархай мэдээллээс сэргийлнэ. Байгууллага, олон нийтийн хамтын ажиллагаа бэхжин - Нэгдсэн урианы дор төрийн болон хувийн хэвшил, иргэдийн хамтын ажиллагаа нэмэгдэж, илүү нөлөөтэй, үр дүнтэй ажил болно. - Салбар дундын уялдаа, харилцан дэмжлэг сайжирч, хуваарилсан үүрэг хариуцлага илүү тодорхой болдог. Зан төлөвт зөрөг өөрчлөлт гарна - Давтамжтай, уялдаа холбоотой уриа, үйл ажиллагаа нь иргэдийн хандлага, зуршлыг өөрчилж, шинэ соёл төлөвшүүлэхэд нөлөөлнө. - Жишээлбэл: зөв галлагаа, аюулгүй хэрэглээ, орчны цэвэрлэгээ, дотоод хяналт гэх мэт дадлууд нийтлэг хэвшил болно. Хэвлэл мэдээлэл, олон нийтийн сүлжээнд нөлөөлөл нэмэгдэнэ - Уриа нь дуу хоолой болж, олон нийтийн сүлжээгээр хуваалцах	
--	--	--	---	--




			боломжтой бол кампанит ажлын нөлөөлөл өргөн хүрээг хамарна. - Нэгдсэн уриа нь сурталчилгаанд хүчтэй мессеж болж, мэдээллийг сануулах, давтах замаар тогтоолгоход үр дүнтэй. Үр дүнг хэмжих, дүгнэхэд хялбар болно - Уриаг дагасан үйл ажиллагаа, оролцооны цар хүрээ, мэдлэгийн түвшинд гарсан өөрчлөлтийг судлан үнэлэх боломж бүрдэнэ. - Кампанит ажлын үр нөлөөг хэмжих шалгуур үзүүлэлтүүд (мэдлэгийн өсөлт, ослын бууралт, хэрэглээний өөрчлөлт гэх мэт) тодорхой болно. Байгууллагын үнэт зүйл, чиглэл олон нийтэд таниулагдана - Кампанит ажлын хүрээнд байгууллагын зорилго, үнэт зүйл, нийгмийн хариуцлага илүү өргөн хүрээнд ойлгогдож, итгэлцэл нэмэгдэнэ. - Иргэд тухайн байгууллагыг эергээр үнэлэх, хамтран ажиллах хандлагатай болно.	
--	--	--	---	--



ЗОРИЛТ ХАМТЫН АЖИЛЛАГААГ ХӨГЖҮҮЛЭХ	5. Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд салбар дундын оролцоог хангах -Зөвхөн хэрэглээ бус үйлдвэрлэлд хяналт хэрэгжүүлэх -Түлшний чанар, үйлдвэрлэлийн хяналт дээрх хамтын ажиллагааг хөгжүүлэх -Шахмал түлшний чанарын лабораторын дүгнэлтэд тогтмол хяналт тавих -Агаарын чанарын хяналтын төхөөрөмжийн сайжруулалт тогтмол хийх -ЭМЯ, НЭМҮТ, Нийслэлийн онцгой байдлын газар зэрэг байгууллагуудтай мэдээлэл солилцох тогтолцоо бүрдүүлэх -Сургалт, хяналт, ослын үед авах арга хэмжээг хамтран төлөвлөх, хэрэгжүүлэх	2025-2030 он	Үйл ажиллагааны уялдаа холбоо сайжирна - Байгууллага дотооддоо болон бусад талуудтай (төр, хувийн хэвшил, иргэд, ТББ) илүү зохион байгуулалттай, уялдаатай ажиллана. - Давхардсан, зөрчилтэй, мэдээлэл зөрсөн үйлдлүүд багасч, цаг хугацаа, нөөцийг хэмнэнэ. Илүү үр дүнтэй шийдвэрүүд гарна - Олон талын оролцоо, санал, туршлагад тулгуурласан шийдвэр нь илүү бодит, иж бүрэн, хэрэгжих чадвартай байдаг. - Нэг чиглэлд хамтарсан шийдэл гаргах замаар эрсдэлийг бууруулж, нөлөөллийг нэмэгдүүлнэ. Нөөц, чадавхыг хуваалцаж, оновчтой ашиглана - Хамтын ажиллагаа нь байгууллагуудын хооронд мэдлэг, тоног төхөөрөмж, хүний нөөц, төсөв зэргийг хуваалцаж, давхар зардлыг бууруулах боломж бүрдүүлнэ.	Санхүүгийн алба Захиргаа, удирдлагын хэлтэс Олон нийттэй харилцах нэгж
--	--	----------------------------	--	---



	-Хамтарсан уулзалт, тайлан, судалгаа хийж бодлого шийдвэрт нөлөөлөх -Хамтрагч байгууллагуудтай салбар дундын оролцоог хангах гэрээ, санамж бичиг байгуулах Иргэдтэй харилцах харилцааг сайжруулах • Цахим апп болон портал: Иргэд өөрсдийн төхөөрөмжийн байдал, сургалтад бүртгүүлэх, мэдээлэл өгөх зэрэг боломжтой платформ бий болгох. • Мессеж, чатбот мэдээллийн систем: Угаарын хийн аюул, аюулгүй ажиллагааны зөвлөмжийг богино хугацаанд олонд түгээдэг системийг хөгжүүлэх.		• Нөөцөө зөв хуваарилснаар үр ашиг нэмэгдэнэ. Инноваци, шинэ санаачилга бий болно • Хамтын ажиллагаа нь өөр өөр талуудын үзэл бодол, арга барил, туршлагыг нэгтгэснээр шинийг сэтгэх, сайжруулсан арга замуудыг гаргах суурь болдог. • Шинэ, үр дүнтэй санаачилгыг хурдан хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ. Итгэлцэл, хариуцлага, хамтын оролцоо төлөвшинө • Нээлттэй, ил тод хамтын ажиллагаа байгууллагуудын болон иргэдийн хоорондын итгэлцлийг нэмэгдүүлж, хамтран оролцох соёлыг төлөвшүүлнэ. • Хариуцлагаа ухамсарласан, идэвхтэй оролцогч талуудтай болох боломж нээгдэнэ. Үйлчилгээний чанар, хүртээмж сайжирна • Талууд уялдаа холбоотой ажилласнаар иргэд, хэрэглэгчдэд хүрч буй үйлчилгээ илүү түргэн
--	--	--	--



	Судалгаа, хамтын ажиллагаа • Их, дээд сургуулиудтай хамтрах: Техник, агаарын бохирдол, хүний эрүүл мэндийн чиглэлээр судалгаа хийж, үр дүнг бодлого боловсруулахад ашиглах. • Олон улсын байгууллагатай харилцах: JICA, GIZ, UNDP гэх мэт хөгжлийн түншүүдээс техник, санхүүгийн дэмжлэг авах боломжийг судлах. Санхүүгийн тогтвортой байдал • Төсөл, тендерээр санхүүжилт босгох: Техник, сургалт, судалгааны чиглэлээр улсын болон олон улсын төсөлд оролцох. • Үйлчилгээний орлого: Засвар үйлчилгээ,		шуурхай, ойлгомжтой, хүртээмжтэй болно. • Давхардалгүй, зөрчилгүй, “нэг цонхны” зарчимтай үйлчилгээ бий болно. Хүртээмжтэй, тогтвортой хөгжлийг дэмжинэ • Хамтын ажиллагаа нь зөвхөн нэг байгууллага биш, бүх талуудын хамтын үр дүнг зорьдог тул нийгмийн тэгш байдал, оролцоог дэмжинэ. • Ялангуяа агаарын бохирдол, угаарын хий зэрэг нийтлэг асуудлуудад хамтын хүчин чармайлт хамгийн чухал нөлөө үзүүлнэ.	
--	---	--	---	--



	угаарын хий мэдрэгч худалдаа зэрэг нэмэлт орлогын эх үүсвэр бий болгох. Төсөл, хөтөлбөрт хамрагдах, түншлэл хөгжүүлэх			
ЗОРИЛТ 6. ДУНД ХУГАЦААНЫ ЗОРИЛТЫН ДҮНГ ҮНЭЛЭХ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ СИСТЕМИЙГ БИЙ БОЛГОХ	Хяналт-шинжилгээ, үнэлгээ (Monitoring & Evaluation) • Сар бүрийн тайлан • Хагас жилийн гүйцэтгэлийн үнэлгээ • Шалгалт, гадны хөндлөнгийн аудит • Иргэдийн сэтгэл ханамжийн судалгаа Жил бүрийн I улиралд гүйцэтгэлийн тайлан гаргаж, төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлнэ. • Зорилт бүрийг SMART шалгуураар (Specific, Measurable, Achievable, Relevant, Time-bound) үнэлж сайжруулалт хийнэ.	2025-2030 он	Байгууллагын соёлыг бий болгох • “Нэг ч иргэн угаартаж болохгүй” гэсэн уриаг уриа лоозон биш, ажил хэрэг болгож, хэн ч орхигдолгүйгээр ханддаг багийн соёлыг төлөвшүүлэх.	Захиргаа, удирдлагын хэлтэс



	Иргэд, хамтрагч байгууллагуудын оролцоог хангана.			
--	---	--	--	--